



**ЗАВХАН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 06 сарын 17 өдөр

Дугаар 4242

Улиастай

**“Үдийн хоол” арга  
хэмжээг батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5.1; 10.5.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 2020 оны 207 дугаар тогтоол, “Төлөвлөгөө батлах тухай” 2021 оны 18 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.3.6 дахь зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ерөнхий боловсролын сургуулиудыг хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд үе шаттайгаар хамруулах зорилгоор “Үдийн хоол” арга хэмжээг нэгдүгээр, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааны хэрэгжилтийг мэргэжил арга зүйн удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллаж, нэгтгэн тайлагнахыг Боловсрол, соёл урлагийн газар (Д.Бямбацогт)-т, хэрэгжилтийг хариуцан ажиллахыг ерөнхий боловсролын сургуулийн захирлуудад тус тус үүрэг болгосугай.

3.Төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусган санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ж.Хүрэлбаатар), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Ж.Батцэнгэл)-т даалгасугай.

4.Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний жагсаалт, аюулгүй байдлыг хангах, нийлүүлэхэд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Н.Батбаяр), хүүхдийн хоол хүнснээс авбал зохих шим тэжээл, илчлэгийн хэмжээ, зохистой хооллолт болон эрүүл хүнсний талаар зөвлөмж гаргаж, мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулж, сургууль дээр тандалт судалгаа хийж, шаардлагатай арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг мэдээлж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Ч.Дэмчигсүрэн), холбогдох дүрэм, журам, стандартыг мөрдүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (А.Даваадорж)-т үүрэг болгосугай.

5.“Үдийн хоол” арга хэмжээний хэрэгжилтийг хагас жил тутамд тайлагнахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (А.Шаравжамц), хэрэгжилт, тайланд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үр дүнг танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (Н.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ТҮВШИНЖАРГАЛ



E/zakhiramj2021

811210713

Аймгийн Засаг даргын 2021 оны 06  
дугаар сарын 17-ны өдрийн  
17-дугаар захирамжийн  
Нэгдүгээр хавсралт

## “ҮДИЙН ХООЛ” АРГА ХЭМЖЭЭ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

8119285296 4 9039287

Дэлхийн улс орнууд сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг нийгмийн халамжийн бодлогын салшгүй нэг хэсэг болгож, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, мэдлэг чадвартай зөв хүн болгон төлөвшүүлэх, тэдний суралцах идэвх, оролцоог нэмэгдүүлэх, сурагчдын насны онцлогт тохирсон хоол, хүнсээр үйлчлэх, шим тэжээлийн мэдлэг, боловсрол олгох харилцааг хуулиар зохицуулан, тусгайлсан хөтөлбөр хэрэгжүүлж, сайн туршлагаудыг хуримтлуулсан байна.

Манай улсад “Тэтгэмж, мөнгөн тусламжийн хэмжээг тогтоох тухай” Улсын Их Хурлын 2006 оны 47 дугаар тогтоол, “Хөтөлбөр хэрэгжүүлэх тухай” Засгийн газрын 2006 оны 194 дүгээр тогтоолын дагуу Ерөнхий боловсролын сургуульд “Үдийн цай” хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүллээ.

Үндэсний аудитын газраас “Үдийн цай” хөтөлбөрт хамрагдаж байгаа сурагчдын 60 орчим хувийг хамруулж, 2007-2008, 2010-2011 оны хичээлийн жилд судалгаа хийсэн бөгөөд уг судалгаагаар 2007-2008 оны хичээлийн жилийн бага ангийн сурагчдын 7 хоногийн дундаж ирц 91.3 хувьтай байсан бол 2010-2011 оны хичээлийн жилд 96.7 хувь болж өссөн байна.

“Үдийн цай” хөтөлбөрийг “Үдийн хоол” болгон хүүхдэд халуун хоолоор үйлчлэхэд ажлын байр, хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг стандартын шаардлагад нийцүүлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх асуудлыг улсын хэмжээнд нэгдсэн бодлогоор шийдвэрлэх шаардлагатай байгаа тухай Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас 2019 онд цэцэрлэг, сургуулийн хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажилд хийсэн хяналт шалгалтын танилцуулгад тэмдэглэсэн байна. Уг танилцуулгад сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудын хоол үйлдвэрлэлийн технологийн урсгал нэг чигийн бус, ялангуяа үдийн цайнд халуун хоол олгох болсонтой холбоотойгоор ерөнхий боловсролын сургуулийн дэргэдэх хоолны газрууд хүчин чадлаасаа 5-10 дахин давсан ачаалалтай ажиллаж, хоол үйлдвэрлэлийн ажиллагаа бүгд нэг дор 30-40 м2 өрөөнд хийгдэж байгаа зөрчил нийтлэг илэрч, хоол, хүнс бохирдох, улмаар халдвар, хордлого гарах эрсдэлийг бий болгож байгаа тухай дурдсан байна.

Эрүүл мэндийн яам, Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүүхдийн сангаас 2017 онд авсан “Монгол Улсын хүн амын хоол тэжээлийн үндэсний V судалгаа”-ны дүнгээс үзэхэд илүүдэл жин, таргалалтын тархалт насанд хүрэгчид, сургуулийн хүүхэд, бага насны хүүхдийн дунд сүүлийн 10 жилийн хугацаанд эрс нэмэгдсэн байна.

Илүүдэл жин, таргалалттай хүүхэд насанд хүрэхэд зүрх судасны өвчин, багтраа, II хэв шинжийн чихрийн шижин зэрэг архаг өвчнөөр өвчлөх эрсдэл өндөр байдаг байна.

Иймд “Үдийн хоол” хөтөлбөрийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бодитой хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх зорилгоор “Алсын хараа 2050”, “Боловсролын салбарын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө (2021-2030)”, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр” (2020-2024), Улсын Их Хурлаас 2019 онд “Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль”-ийг баталж, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 207 дугаар тогтоолоор “Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих үндэсний хөтөлбөр, 2021 оны 18 дугаар тогтоолоор “Ерөнхий боловсролын сургуулиудыг үдийн хоолны үйлчилгээнд үе шаттай хамруулах төлөвлөгөө”, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны А/65 дугаар тушаалаар “Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг тус тус батлан, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр (2020-2024), аймгийг хөгжүүлэх үндсэн чиглэл (2021-2025) зэрэг бодлогын баримт бичгүүдэд тусгасан хэрэгжүүлж байна.

### ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ.

2020-2021 оны хичээлийн жилд аймгийн хэмжээнд төрийн өмчийн ерөнхий боловсролын 29 сургууль сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж, 15535 (Үүнээс бүрэн дунд боловсролд 2646, суурь боловсролд 5587, бага боловсролд 7302) суралцагч суралцаж, 1663 багш ажилтан ажиллаж байгаагаас 60 тогооч, 17 туслах ажилтан ажиллаж байна.

Үдийн цай хөтөлбөрт хамрагдаж байсан бага боловсролын 7302 суралцагч буюу нийт суралцагчийн 46,9 хувь нь үдийн хоол хөтөлбөрт хамрагдаж байна.

Сургуулиар нь авч үзвэл:

Алдархаан 48, Асгат 125, Баянтэс 237, Баянхайрхан 138, Дөрвөлжин 130, Завханмандал 65, Идэр 219, Тосонцэнгэл I сургууль 498, Их-Уул 682, Нөмрөг 174, Отгон 201, Сантмаргаз 154, Сонгино 151, Тосонцэнгэл II сургууль 684, Түдэвтэй 158, Тэлмэн 237, Тэс 282, лаборатори Чандмань-Эрдэнэ сургууль 686, Жавхлант цогцолбор сургууль 615, Улиастай III сургууль 356, Улиастай IV сургууль 204, Дэвшил сургууль 580, Ургамал 126, Цагаанхайрхан 54, Цагаанчулуут 97, Цэцэн-Уул 116, Шилүүстэй 137, Эрдэнэхайрхан 91, Яруу 66

ЕБС-ийн 15% нь сайжруулсан ус ариун цэврийн байгууламжтай.

Сургуулийн хоолны газраа түрээсээр ажиллуулдаг 2 сургууль, хоолны газрыг стандартад нийцүүлэн засварлах шаардлагатай 10 сургууль, үндсэн болон нэмэлт тоног төхөөрөмж шаардлагатай 22 сургууль, ердийн гал тогоонд хоолоо хийж байгаа 4 сургууль байна.

Хүний нөөцийн хувьд 17 тогооч, туслах ажилтан 8 шаардлагатай бөгөөд хоол зүйчийн орон тоог шинээр нэмэгдүүлэх шаардлага үүсч байна.

### ХОЁР. ЗОРИЛГО

Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдыг “Үдийн хоол” арга хэмжээнд үе шаттайгаар хамруулахад оршино.

### ГУРАВ. ЗОРИЛТ

3.1.Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд тулгуурласан, стандартын шаардлага хангасан хоол, хүнсний хангамжийг бүрдүүлэх;

3.2.Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний газрыг стандартын шаардлагад нийцүүлэх, хөндлөнгийн болон дотоод хяналтыг сайжруулах замаар хоол, хүнсний аюулгүй байдлыг хангах;

3.3.Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд ажиллах хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах;

3.4.Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээгээр дамжуулан боловсролын үйлчилгээнд оролцогч талуудын хоол, шим тэжээлийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх;

### ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

*1. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд тулгуурласан, стандартын шаардлага хангасан хоол, хүнсний хангамжийг бүрдүүлэх зорилтын хүрээнд:*

1.1. Сургуулиуд "Сургалт туршилтын талбай" байгуулж, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнийг тарьж, сургуулийн хоол үйлдвэрлэлд ашиглах;

1.2. Сургуулийн гадна талбайд гүний худаг гаргаж ундны усны эх үүсвэрээр хангах;

1.3.Орон нутгийн хүнсний үйлдвэрлэл, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, тариалалт борлуулалтын үйл ажиллагааг бодлогоор үе шаттай дэмжих;

1.4.Сургуулийн хоол үйлдвэрлэлийн хүнсний хангамжийг орон нутгийн онцлогт тохируулан үе шаттай шийдвэрлэх

1.5. Сургууль дотор стандартын шаардлага хангасан ундны усаар үйлчлэх нөхцөлийг бүрдүүлэх;

1.6. Сургуулийн дэргэдэх туслах аж ахуйг хөгжүүлэх;

*2. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний газрыг стандартын шаардлагад нийцүүлэх, хөндлөнгийн болон дотоод хяналтыг сайжруулах замаар хоол, хүнсний аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд:*

2.1.Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний дотоод хяналтын журмыг боловсруулан хэрэгжүүлэх;

2.2. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрыг стандартын шаардлагад нийцүүлэн үе шаттай засварлах;

2.3. Сургуулийн хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг үе шаттай нийлүүлэх;

2.4. ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын түрээсийн гэрээг дуусгавар болгох;

2.5. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих орон тооны бус хяналтын зөвлөлийг байгуулах;

2.6. Сургуулийн хоолны газар, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, хүний нөөцийн цахим сантай болох;

*3. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд ажиллах мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах зорилтын хүрээнд:*

3.1 Хоёр ба түүнээс дээш хичээлийн байртай сургуулийн хоол үйлдвэрлэлийн газрыг нэгтгэх, тоног төхөөрөмж, хүний нөөц, хүнсний хангамжийг оновчтой төлөвлөх;

3.2 Сургуулийн удирдлага, эмч, нярав, нягтлан бодогч, дотуур байрын багш, тогооч нарыг чадавхжуулах болон мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах;

3.3. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажилтны нийгмийн баталгааг сайжруулах, орон тоог нэмэгдүүлэх;

3.4. Сургуулийн эмч болон хоол хүнсний чиглэлийн мэргэжлийн ажиллагсдыг хоол зүйчээр хөрвүүлэн бэлтгэх;

*4. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээгээр дамжуулан боловсролын үйлчилгээнд оролцогч талуудын хоол, шим тэжээлийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх зорилтын хүрээнд:*

4.1. Эцэг эх, асран хамгаалагч, багш ажилтны хоол, шим тэжээлийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулж, сурталчилгааг нэмэгдүүлэх;

4.2. Мэргэжлийн байгууллагатай хамтран цахим зөвлөмж, хичээлүүдийг байршуулах.

## **ДӨРӨВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА**

Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хүрээнд холбогдох хууль тогтоомж, үндэсний хөтөлбөр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан 2021-2024 онд хэрэгжүүлнэ.

## **ТАВ. ХАМРАХ ХҮРЭЭ**

Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчид, төрийн болон төрийн бус байгууллага, эцэг, эх, иргэд

### ЗУРГАА. САНХҮҮЖИЛТ

“Үдийн хоол” арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

- 6.1. Улсын болон орон нутгийн төсөв;
- 6.2. байгууллагын өөрийн хөрөнгө;
- 6.3. иргэн, аж ахуйн нэгжийн хандив;
- 6.4. олон улсын болон гадаад улсын зээл, тусламж;
- 6.5. хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

### ДОЛОО. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ҮР ДҮН

д/д	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин			
				2021	2022	2023	2024
1	"Сургалт туршилтын талбай" байгуулсан сургууль	тоо	3	6	7	9	11
2	Гадна талбайд гүний худаг гаргаж ундны усны эх үүсвэрээр хангасан сургууль	тоо	7	8	0	0	0
3	Стандартын шаардлага хангасан ундны усаар үйлчилж байгаа сургууль	тоо	15	16	20	24	29
4	Дэргэдээ туслах аж ахуйг хөгжүүлсэн сургууль	тоо	4	5	7	8	9
5	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрыг стандартын шаардлагад нийцүүлэн засварласан сургууль	тоо	7	8	11	14	18
6	Хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг шинэчилсэн сургууль	тоо	7	9	11	15	19
7	Хоолны газар, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, хүний нөөцийн цахим сантай болсон сургууль	тоо	0	29	29	29	29
8	Чадавхжуулах сургалтад оролцогчид	тоо	60	80	120	130	145

9	Хоол зүйчийн орон тоо	тоо	0	1	2	3	4
10	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний мэргэжлийн ажилтны орон тоо	тоо	60, 17	60, 17	60, 17	60, 17	60, 17
11	Хоол, шим тэжээлийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх сургалтад оролцогчид	тоо	100	200	300	450	600

### НАЙМ. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ

8.1.Аймгийн Боловсрол, соёл урлагийн газар мэргэжил арга зүйн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

8.2.Ерөнхий боловсролын сургуулиуд хэрэгжилтийг хариуцан ажиллаж, хагас, бүтэн жилийн тайланг Боловсрол, соёл урлагийн газарт тайлагнаж, хэвлэмэл болон файлаар ирүүлнэ.

8.3.“Үдийн хоол” арга хэмжээний хэрэгжилт, тайланд аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, мөн Иргэний нийгмийн байгууллагын зүгээс төрийн байгууллагатай хамтран үнэлгээ хийнэ.

8.4 Хэрэгжилтийн явцын үнэлгээг үндэслэн өөрчлөлт оруулж болно.

-----000-----

Аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 42/Удугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

"ҮДИЙН ХООЛ" АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)						Хүрэх түвшин	Төсөв	Хэрэгжүүлэх байгууллага				
						2021		2022		2023					Хүрэх түвшин	Төсөв	Хүрэх түвшин	Төсөв
						Хүрэх түвшин	Төсөв	Хүрэх түвшин	Төсөв	Хүрэх түвшин	Төсөв							
Нэг. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд тулгуурласан, стандартын шаардлага хангасан хоол, хүнсний хангамжийг бүрдүүлэх зорилтын хүрээнд:																		
1	Сургуулиуд "Сургалт туршилтын талбай" байгуулж, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэийг тарьж, сургуулийн хоол үйлдвэрлэлд ашиглах;	БӨХ	11.5	сургуулийн тоо	3	6	2.0	7	2.5	9	3.0	11	4.0	ЕБС	БСУГ	ХХААГ, СЗДТГ		
2	Сургуулийн гадна талбайд гүний худаг гаргаж ундны усны эх үүсвэрээр хангах;	БӨХ, ОНТ	15.0	Гүний худагтай сургуулийн тоо	7	8	15.0							ЕБС	БСУГ	СЗДТГ, МХГ		
3	Орон нутгийн хүнсний үйлдвэрлэл, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, тариалалт борлуулалтын үйл ажиллагааг бодлогоор үе шаттай дэмжих	ОНТ	15.0	Хэрэгжилтээр	7	8	1.0	11	2.5	15	5.0	17	6.5	ЕБС	БСУГ	СЗДТГ, ХХААГ		
4	Сургууль дотор стандартын шаардлага хангасан ундны усаар үйлчлэх нөхцөлийг бүрдүүлэх;	ТХ	4.0	Стандарт хангасан ундны устай сургуулийн тоо	15	16	0.5	20	2.0	24	2.0	29	2.5	ЕБС	БСУГ	МХГ		
		БӨХ	3.0															
5	Сургуулийн хоол үйлдвэрлэлийн хүнсний хангамжийг орон нутгийн онцлолт тохируулан үе шаттай шийдвэрлэх	ББӨХ, ОНТ	11.0	хэрэгжилтээр	6	7	2.0	8	2.0	11	3.5	13	3.5	ЕБС	БСУГ	ХХААГ, СЗДТГ		
6	Сургуулийн дэргэдэх туслах аж ахуйг хөгжүүлэх;	БӨХ	10.0	Туслах аж ахуйтай болсон сургуулийн тоо	4	5	1.0	7	2.0	8	3.0	9	4.0	ЕБС	БСУГ	ХХААГ, СЗДТГ		
			28.0				3.5	6.0	8.5	10.0								
1-р зорилтын мөнгөн дүн																		
Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний газрыг стандартын шаардлагад нийцүүлэх, хөндлөнгийн болон дотоод хяналтыг сайжруулах замаар хоол, хүнсний аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд:																		
1	Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний дотоод хяналтын журмыг боловсруулан хэрэгжүүлэх	0	0	Хэрэгжилтээр	29	29	0	29	0	29	0	29	0	ЕБС	БСУГ	БШУЯ		
2	Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрыг стандартын шаардлагад нийцүүлэн үе шаттай засварлах;	ОНТ	50.0	Стандартын шаардлагад нийцсэн сургуулийн тоо	7	8	3.0	11	15.0	14	15.0	18	17.0	ЕБС	БСУГ	Аймаг, СЗДТГ		



№	Сургуулийн хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг үе шаттай нийлүүлэх	УТ		сургуулийн тоо	7	9	10.0	11	10.0	15	15.0	19	15.0	ЕБС	БСУГ	Аймаг, СЗДТГ
		ОНТ	ТХ													
3	ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын түрээсийн гэрээг дуусгавар болгох	30.0	10.0	10	8	6	10.0	11	10.0	4	15.0	2	15.0	ЕБС	БСУГ	СЗДТГ
4	Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих орон тооны бус хяналтын зөвлөлийг байгуулах			0	100%	100%		100%		100%		100%		ЕБС	БСУГ	СЗДТГ
5	Сургуулийн хоолны газар, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, хүний нөөцийн цахим сантай болох			0	29	29	13.0	29	10.0	29	25.0	29	30.0	ЕБС	БСУГ	СЗДТГ
2-р заалтын мөнгөн дүн				100.0												
Гурав. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд ажиллах мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах зорилтын хүрээнд:																
1	Хоёр ба түүнээс дээш хичээлийн байртай сургуулийн хоол үйлдвэрлэлийн газрыг нэгтгэх, тоног төхөөрөмж, хүний нөөц, хүнсний хангамжийн тогтолцоог оновчтой төлөвөх			5		2		2		2		1		ЕБС	БСУГ	СЗДТГ
2	Сургуулийн удирдлага, эмч, нярав, нягтлан бодогч, дотуур байрын багш, тогооч нарыг чадавхжуулах болон мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах	ОНТ	5.0	60	80	120	2.0	120	2.0	130	2.5	145	3.0	ЕБС	БСУГ	СЗДТГ
		ТХ	5.0													
3	Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажилтны нийгмийн баталгааг сайжруулах, орон тоог нэмэгдүүлэх	УТ		тогооч 60, туслах 17	тогооч 65, туслах 19	тогооч 69, туслах 21				тогооч 73, туслах 23		тогооч 77, туслах 25		ЕБС	БСУГ	СЗДТГ
4	Сургуулийн эмч болон хоол хүнсний чиглэлийн мэргэжлийн ажиллагсдыг хоол зүйчээр хөрвүүлэн бэлтгэх			0	1	2				3		4		ЕБС	БСУГ	СЗДТГ
3-р заалтын мөнгөн дүн				10.0			2.0	2.5	2.5	2.5		3.0				
Дөрөв. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээгээр дамжуулан боловсролын үйлчилгээнд оролцогч талуудын хоол, шим тэжээлийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх зорилтын хүрээнд:																

1	Эцэг эх, асран хамгаалагч, багш ажилтны хоол, шим тэжээлийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулж, сурталчилгааг нэмэгдүүлэх;	ОНТ	5.0	Зохихон байгуулсан сургалтын тоо Оролцогчдын тоо	100	2000	0.5	300	1.0	450	1.5	600	2.0	ЕБС	БСУГ	ЭМГ
2	Мэргэжлийн байгууллагатай хамтран цахим зөвлөмж, хичээлүүдийг байршуулах	ОНТ	5.0	Зөвлөмжийн тоо, хэрэглэгчдийн тоо	60	100	0.5	200	1.0	300	1.5	500	2.0	ЕБС	БСУГ	ЭМГ
	4-р заалтын мөнгөн дүн		10.0				1		2.0		3.0		4.0			
	Нийт мөнгөн дүн		189.5				19.5		35.5		44.0		49.0			
			ОНТ-140.5			2021.ОНТ-22.5		2022.ОНТ-41.0		2023.ОНТ-32.5		2024.ОНТ-44.5				
			УТ-30.0							2023.УТ-15.0		2024.УТ-15.0				
			ТХ-19.0					2022.ТХ-14.5		2023.ТХ-4.5						